



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Чойр

Комисс томилох тухай

Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 8, 9, 10, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргалын гаргасан гомдлыг хянан шалгаж, дүгнэлт гаргах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

КОМИССЫН ДАРГА

Д.СУВД- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Д.МАГВАНСҮРЭН- Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

ГИШҮҮН

Ж.ОЮУНБИЛЭГ- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2. С.Мөнхжаргалын гаргасан гомдлыг нягтлан шалгаж, комиссын санал, дүгнэлтийг журамд заасан хугацааны дотор Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комисс /Д.Сувд/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 02

Чойр

Комисс томилох тухай

Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 4.3, 8, 9, 10, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайханы гаргасан хүсэлтийг хянан шалгаж, дүгнэлт гаргах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

КОМИССЫН ДАРГА

Б.ГАНБАЯР-Аймгийн Мэргэжлийн  
хяналтын газрын дарга, Төрийн албаны  
зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

ГИШҮҮД

Д.МАГВАНСҮРЭН- Хууль эрх зүйн  
хэлтсийн дарга, Төрийн албаны  
зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн  
Б.БАТТӨР- Аймгийн Тагнуулын тасгийн  
дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн гишүүн

2. Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайханы гаргасан хүсэлтийг нягтлан шалгаж, комиссын санал, дүгнэлтийг журамд заасан хугацааны дотор Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комисс /Б.Ганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 03

Чойр

Ёс зүйн хороог шинэчлэн  
байгуулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах, эрх бүхий байнгын Ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

ДАРГА:

Д.МАГВАНСҮРЭН - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:  
ГИШҮҮД:

Д.МӨНХЗУЛ - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.БАТ-ЭРДЭНЭ - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Д.МӨНХ-ЭРДЭНЭ - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Д.ЗАНДАРЪЯА - Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон төрийн захиргааны албан хаагчийн тоо 10 хүрэхгүй, тусдаа Ёс зүйн хороогүй байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг шалган тогтоож, дүгнэлт гаргах үүргийг журмын дагуу гүйцэтгэж, дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулж байхыг Ёс зүйн хорооны дарга /Д.Магвансүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.СОДНОМ





ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 04

Чойр

Ажлын хэсгийн дүгнэлтийг  
хэлэлцсэн тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Улсын Их Хурлын 2003 оны “Журам батлах тухай” 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 1 дүгээр бүлгийн 4.3, 3 дугаар бүлгийн 15, 16, 18, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргалаас гаргасан өргөдлийг хянан үзээд, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэлийг тогтоолгүйгээр арга хэмжээ авсан байна гэж үзээд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Б/37 дугаар тушаал нь илт хууль бус шийдвэр байна гэсэн комиссын дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Захиргааны ерөнхий хуулийн 25, 26, 27, 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй шийдвэр гаргасан тул дээрх шийдвэрээ хүчингүй болгохыг аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга /Отгонсүрэн/-д даалгасугай.

3. Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргалд өргөдлийн хариуг ажлын 10 өдөрт багтаан хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, комиссын дарга /Д.Сувд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 05

Чойр

Ажлын хэсгийн дүгнэлтийг  
хэлэлцсэн тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Улсын Их Хурлын 2003 оны “Журам батлах тухай” 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 1 дүгээр бүлгийн 4.3, 3 дугаар бүлгийн 15, 16, 18, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайханы ирүүлсэн хүсэлтийг хянан үзээд Засаг даргын Тамгын газрын дарга Г.Уранчимэг нь Сүмбэр сумын 1 дүгээр багийн Иргэдийн Нийтийн Хурлын даргын ажлыг давхар эрхэлж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 15 дугаар зүйлийн 15.1.8, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн комиссын дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайханд албан тоотын хариуг ажлын 10 өдөрт багтаан хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн /Б.Ганбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 06

Чойр

Г М.Анхбаярыг удирдах албан тушаалд Г  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар зүйлийн 14.а, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.2, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд бэлтгэгдсэн байдал, мэргэшлийн түвшин, тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Мөнхбадрахын Анхбаярын нэрийг дэвшүүлсүгэй.

2. Мөнхбадрахын Анхбаярыг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ  
УХА0115  
06



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 07

Чойр

О.Болор-Эрдэнийг нөөцөөс  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.2.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3.5, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2015 онд зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 166 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэгдсэн иргэн Октябрийн Болор-Эрдэнийг нэрийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлын асуудал хариуцсан мэргэжилтнээр дэвшүүлсүгэй.

2. Иргэн О.Болор-Эрдэнийг нэр дэвшүүлсэн албан тушаалд томилон ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Содном/-д санал болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 08

Чойр

Төрийн албаны тэргүүний ажилтан  
тэмдгээр шагнуулахаар уламжлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.6, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 3.2, 3.3, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж, байгаль орчин, газрын харилцааны чиглэлд орон нутагт оруулсан бодитой хувь нэмрийг үнэлж, “Төрийн албаны тэргүүний ажилтан” шагналын болзол, шалгуурыг хангасан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Дөшийн Ганзоригийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар уламжилсугай.

2. Шагналын материал, холбогдох баримт бичгийг журамд заасны дагуу Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь Салбар зөвлөлийн гишүүн /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115  
06





**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 09

Чойр

**Төрийн захиргааны албан хаагчийн  
тангараг өргүүлэх санал батлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2003 оны “Журам батлах тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол журам”-ын 6, 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.12, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, туршилтын хугацаагаар ажиллаж байх хугацаандаа цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан аймгийн Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, байгууллагын ил тод байдал хариуцсан мэргэжилтэн Дашхорлоогийн Нарансолонго, Хуулийн зөвлөх, архив бичиг хэрэг, даргын туслах хариуцсан мэргэжилтэн Даваадоржийн Номин, Мэргэжлийн хяналтын газрын Барилга, техникийн хяналтын улсын байцаагч Энхбатын Амарсайхан, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал Баяраагийн Баасанбат, Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн Бэлчээр, газар тариалан, худаг ус хариуцсан мэргэжилтэн Лувсандоржийн Хулан, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Мэдээллийн сан, техник программ хангамж хариуцсан мэргэжилтэн Батзулын Мянганбаяр нарыг Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагч болгох саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

УХА0115  
06



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 10

Чойр

Төрийн захиргааны албан хаагчдад  
зэрэг дэв олгох санал батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2.5, 2.2.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

2. Аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан болон тухайн албан тушаалд ажилласан хугацаа, төрийн албан хаагчдын 2016 оны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн олгох төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийн саналыг хавсралт ёсоор баталсугай.

3. Төрийн захиргааны албан хаагчдад ахлах, дэс, туслах түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох саналыг журмын дагуу аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ

УХА0115  
05

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ САНАЛТАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭРС**

№	Албан хаагчдын нэрс	Байгууллага, албан тушаал	Ажилласан жил		Үр дүнгийн гэрээний үнэлгээ /2016 он/	Олгох зэрэг дэв
			Төрийн албанд	Тухайн албан тушаалд		
1	Т.Бат-Эрдэнэ	Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	7 жил	1 жил	В	Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг
2	Н.Одонтуяа	Аймгийн ЗДТГазрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	8 жил	2 жил	А	Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг
3	Ц.Отгончимэг	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтсийн Дотоод ажил, өргөдөл, гомдол, санал хүсэлт хариуцсан мэргэжилтэн	5 жил	2 жил	А	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
4	Д.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	13 жил	3 жил	А	Ахлах түшмэлийн Тэргүүн зэрэг
5	Ц.Мөнх-Од	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга	11 жил	3 жил	А	Ахлах түшмэлийн дэд зэрэг
6	Б.Тогтох	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга, Сувилахуй, ахмад настан, хөнгөвчлөх, уламжлалт, нөхөн сэргээх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	28 жил	7 жил	А	Дэс түшмэлийн тэргүүн зэрэг
7	П.Дашцэрэн	Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа, дэмжих сан, нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	12 жил	3 жил	В	Дэс түшмэлийн гутгаар зэрэг
8	Г.Болортуяа	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга	5 жил	1 жил	А	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
9	Б.Базаррагчаа	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Шивээговь сум хариуцсан мэргэжилтэн	9 жил	5 жил	В	Дэс түшмэлийн гутгаар зэрэг

10	Б.Болормаа	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн	24 жил	9 жил	A	Дэс түшмэлийн тэргүүн зэрэг
11	С.Энх-Амгалан	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн	24 жил	7 жил	B	Дэс түшмэлийн дэд зэрэг
12	Б.Гарамсан	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Соёл хариуцсан ахлах мэргэжилтэн	6 жил	6 жил	B	Дэс түшмэлийн гутгаар зэрэг
13	С.Батцэцэг	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Төсвийн мэргэжилтэн	9 жил	1 жил	B	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
14	Л.Одонтуяа	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны мэргэжилтэн	5 жил	1 жил	A	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
15	Б.Анхтуяа	Биеийн тамир, спортын газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга	8 жил	3 жил	A	Дэс түшмэлийн гутгаар зэрэг
16	М.Батдэлгэр	Биеийн тамир, спортын газрын Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга	8 жил	3 жил	A	Дэс түшмэлийн гутгаар зэрэг
17	Д.Мөнхжаргал	Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	7 жил	1 жил	A	Дэс түшмэлийн дэд зэрэг
18	Ц.Алтанцэцэг	Сүмбэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга	8 жил	1 жил	A	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
19	С.Анхбаяр	Сүмбэр сумын ЗДТГ-ын 1-р багийн нийгмийн ажилтан	3 жил	3 жил	B	Туслах түшмэлийн дөтгөөр зэрэг
20	Х.Мөнхжаргал	Шивээговь сумын ЗДТГ-ын дарга	26 жил	2 жил	A	Дэс түшмэлийн гутгаар зэрэг
21	У.Чулуунцэцэг	Шивээговь сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга	22 жил	1 жил	A	Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг
22	О.Даваажав	Шивээговь сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн	11 жил	4 жил	A	Туслах түшмэлийн гутгаар зэрэг
23	Э.Баярмагнай	Шивээговь сумын ЗДТГ-ын Газрын даамал	7 жил	7 жил	A	Туслах түшмэлийн гутгаар зэрэг